

ТАНЫ СОНГОСОН ЗАМ АЛЬ НЬ ВЭ?



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

COWI

EBP



ИКОН ХХК

УЛААНБААТАР ХОТЫН АХУЙН ХОГ ХАЯГДЛЫН ЦУГЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 3-р хороо, Энхтайваны өргөн
чөлөө, Пийс тауэр 15 давхар 1503 тоот

7011 1220

wastemanagement@icon.mn

www.waste.ub.gov.mn

UB waste

ТУРШИЛТЫН ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БУЙ
ХОРООНЫ АЙЛ ӨРХӨӨС ХОГ ХАЯГДЛЫГ
ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЕД ЖОЛООЧ,
АЧИГЧ НАРЫН ДАГАЖ МӨРДӨХ

АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

COWI

EBP



ИКОН ХХК



ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ БАРИМТЛАХ

Энгийн хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.



Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.



Дүүргийн Засаг даргын баталсан хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх хуваарийг мөрдөж ажиллана.



Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг мөрдөх

- Хог тээврийн авто машины бүрэн, бүтэн байдлыг ажилд гарахаас өмнө шалгаж, ажилд гарах зөвшөөрөл өгөх бөгөөд бүрэн бус тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гаргахгүй байх;
- Энгийн хог хаягдлыг авто машины даац, тэвшний өндөрт тохируулан ачиж, битүүмжлэн тээвэрлэх ба тээвэрлэлтийн явцад хог хаягдал хийсэх, тархах, асгарахаас сэргийлэх арга хэмжээ авах;
- Энгийн хог хаягдлыг ачиж, тээвэрлэсний дараа тээврийн хэрэгсэл болон тэвшийг тогтмол цэвэрлэж, сард хоёроос доошгүй удаа ариутгал, халдваргүйжүүлэлт хийх;
- Хог хаягдал ачсан үед ачаан дээр хүн тээвэрлэхгүй байх;
- Энгийн хог хаягдлыг холихгүйгээр ангиллын төрлийн дагуу ачиж, тээвэрлэх;

- Энгийн хог хаягдлыг ачиж, цуглуулах үед галын аюулгүй байдлыг хангаж, хог ачих цэгээс 10 метрээс дотогш гал гаргахгүй байх;
- Энгийн хог хаягдлыг ачиж, цуглуулах үед ууталсан хог хаягдлыг уутнаас задлахгүйгээр, хог хаягдлыг ил задгай тархааж хийсгэхгүйгээр ачиж тээвэрлэх;
- Энгийн хог хаягдлыг ачсаны дараа хогийн сав, бункер болон орчныг цэвэрлэн эзэмшигчид хүлээлгэж өгөх;
- Энгийн хог хаягдал тээвэрлэх хуваарь, чиглэл өөрчлөх тохиолдолд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 72 цагийн өмнө мэдэгдэх.

ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ СТАНДАРТ, ШААРДЛАГА



ХАШААНДАА АНГИЛАН ЯЛГАСАН ХОГИЙН САВТАЙ АЙЛ, ӨРХӨӨС ХОГ ХАЯГДЛЫГ ХЭРХЭН АЧИХ ВЭ?



- Айл, өрхийн хашаанд дахин ашиглах боломжтой хог хаягдал, дахин ашиглах боломжгүй хог хаягдал гэсэн 2 төрлийн хогийн сав байна.
- Хогийн савнаас дахивар хогийг ачихдаа тусгай түлхүүрийг ашиглан ногоон өнгийн хаалгыг онгойлгон дотор талд байгаа хог хаягдлын савыг бариулаас барин татаж гарган хог ачихын өмнө хог хаягдлыг зөв ангилан хаясан байдлыг хянана. Хэрэв ангилсан хог хаягдлыг бусад хогтой холисон бол айл өрхөд мэдэгдэж, бусад хог хаягдлын саванд хийнэ. Дахивар хог хаягдлыг машинд ачсаны дараа хогийн савыг буцааж байрлуулан тусгай түлхүүрээр түгжин хогийн савны хажууд байрлах QR кодыг ухаалаг утасны апп нээж уншуулан төрөлжүүлэн ангилах байгууламж руу тээвэрлэнэ.

- Хогийн савнаас бусад хог хаягдлыг ачихдаа тусгай түлхүүрийг ашиглан саарал өнгийн хаалгыг онгойлгох бөгөөд дотор талд байгаа хог хаягдлын савыг бариулаас барин татаж гаргана. Хогийг ачихын өмнө түүнийг зөв ангилан хаясан байдлыг хянана. Хэрэв бусад хог хаягдалд дахивар хог хаягдал хольсон бол айл өрхөд мэдэгдэж, дахивар хог хаягдлын саванд хийнэ. Бусад хог хаягдлыг машинд ачсаны дараа хогийн савыг буцааж байрлуулан тусгай түлхүүрээр түгжин хогийн савны хажууд байрлах QR кодыг ухаалаг утасны апп нээж уншуулан төвлөрсөн цэг рүү тээвэрлэнэ.
- Айл өрхүүд сайжруулсан түлшнээс гарсан үнсийг цогшилт байхгүй бүрэн хөрсөн үед шуудайлсан байх бөгөөд түүнийг тусгайлан байрлуулсан хэсгээс ачина. Ачих үед үнс хийсэх, уут задрахаас сэргийлнэ. Үнсийг дахин боловсруулах үйлдвэр рүү тээвэрлэнэ.





НИЙТИЙН ХОГИЙН ЦЭГЭЭС ХОГ ХАЯГДЛЫГ ХЭРХЭН АЧИХ ВЭ?



- Нийтийн хогийн цэгт айл өрхүүд хог хаягдлаа 3 төрлөөр буюу дахин боловсруулах, бусад, үнс гэж ангилна.
- Нийтийн хогийн цэг дэх хог хаягдал дүүрч халихаас өмнө хог хаягдлыг ангиллын дагуу ачна. **Дахивар хог хаягдлын сав нь ногоон өнгөтэй** байх ба хог ачихаас өмнө шалгаж дахивараас бусад хог хаягдлыг хольсон бол бусад хог хаягдлын савруу хийнэ.

- Хогийг ачиhaас өмнө хогийн саван дээр байрлах QR кодыг уншуулж баталгаажуулна.
- Хогийн савны түгжээг салган тусгай өргөгч төхөөрөмжийг ашиглан хогийн савнаас хог хаягдлыг машинд ачиж суллана.
- Хог хаягдал ачих үед салхинд хийсэж, тархахаас сэргийлэх бөгөөд хогийн цэгийн ойр орчинг цэвэрлэнэ.
- Хогийн савыг хуучин байрлалд нь байрлуулан түгжээд хог хаягдлыг төрөлжүүлэн ангилах байгууламж руу тээвэрлэнэ.



- **Бусад хог хаягдлын сав нь хар саарал өнгөтэй** байх бөгөөд хог ачихаас өмнө шалгаж дахивар хог хаягдлыг хольсон бол дахивар хог хаягдлын саванд хийнэ.
- Хогийг ачихаас өмнө хогийн саван дээр байрлах QR кодыг уншуулж баталгаажуулна.
- Хогийн савны түгжээг салган тусгай өргөгч төхөөрөмжийг ашиглан хогийн савнаас хог хаягдлыг машинд ачиж суллана.
- Хог хаягдал ачих үед салхинд хийсэж, тархахаас сэргийлэх бөгөөд хогийн цэгийн ойр орчинг цэвэрлэнэ.

- Хогийн савыг хуучин байрлалд нь байрлуулан түгжээд хог хаягдлыг хог хаягдлын төвлөрсөн цэг рүү тээвэрлэнэ.

- **Үнсний хог хаягдлын сав нь саарал өнгөтэй** байх бөгөөд хог ачихаас өмнө шалгаж дахивар болон бусад хог хаягдлыг хольсон бол дахивар хог хаягдлын болон бусад хог хаягдлын савруу хийнэ.

- Хогийг ачихаас өмнө хогийн саван дээр байрлах QR кодыг уншуулж баталгаажуулна.

- Хогийн савны түгжээг салган тусгай өргөгч төхөөрөмжийг ашиглан хогийн савнаас хог хаягдлыг машинд ачиж суллана.

- Хог хаягдал ачих үед салхинд хийсэж, тархахаас сэргийлэх бөгөөд хогийн цэгийн ойр орчинг цэвэрлэнэ.

- Хогийн савыг хуучин байрлалд нь байрлуулан түгжээд хог хаягдлыг үнс дахин боловсруулах үйлдвэрлүү тээвэрлэнэ.



ДАХИВАР ХҮЛЭЭН АВАХ ЦЭГЭЭС ХОГИЙГ ХЭРХЭН АЧИХ ВЭ?



Дахивар хүлээн авах цэгээс ачих дахин боловсруулах хог хаягдалд хатуу, зөөлөн хуванцрууд, гялгар уут, шил, хөнгөн цагаан лааз, цаас зэрэг орно. Энэ төрлийн хог хаягдлыг Дахивар хүлээн авах цэгээс ачиж **QR кодыг уншуулан** төрөлжүүлэн ангилах байгууламж руу тээвэрлэнэ.

ТӨРӨЛЖҮҮЛЭН АНГИЛАХ БАЙГУУЛАМЖИД ДАХИВАРЫГ ХЭРХЭН ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ ВЭ?




Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг тээвэрлэн **Төрөлжүүлэн ангилах байгууламжид** хүргэж, **QR кодыг уншуулан** тусгайлан бэлтгэсэн талбайд буулгана.

ҮНС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРТ ҮНСЭЭ ХЭРХЭН ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ ВЭ?




Үнс боловсруулах үйлдвэрт хог хаягдлыг хүргэн **QR кодыг уншуулан** тусгайлан бэлтгэсэн талбайд буулгана.

ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛЖ ТЭЭВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛУУД



- Гэр хороонд байрлуулсан хогийн савнаас хог хаягдлыг ачиж, цуглуулахдаа хогийн савыг шидэх, дээр нь суух, гишгэх гэх мэтээр механик гэмтэл учруулахаас болгоомжлоорой.
- Хог хаягдлыг ачиж байх үед тамхи татах болон гал гаргаж болохгүй шүү.
- Хогийн савыг авч явах, буцаан байрлалд нь хийхгүй гадна талд орхихыг хориглоно.
- Хогийн савыг байрлуулан буцааж түгжихээ мартуузай!



QR КОД УНШУУЛАХ ЗААВАР

Хог хаягдлыг айл өрх, нийтийн хогийн цэг, рисайкл шопоос ачиж тээвэрлэх, буулгах үед хогийн савны зэргэлдээ байрлуулсан QR кодыг уншуулахдаа гар утасны апп нээж хогийн савууд дээр байрлуулсан **QR кодыг уншуулж** хог ачихаас өмнөх болон ачсаны дараах **фото зургийг авч хадгална.**